



**ХОТ ТӨЛӨВЛӨЛТ, СУДАЛГААНЫ ИНСТИТУТ ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Г Ажлын хэсэг байгуулах тухай. Г

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.8.7 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/578 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль 2022 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхтэй холбогдуулан биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг цуглуулахад үндэслэл болгосон дүрэм, журмыг Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуультай нийцүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийг тайлагнахыг Захиргаа удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга (Л.Эрдэнэбат)-д даалгасугай.

3. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт заасны дагуу биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ)-ийг устгах үйл ажиллагааг зохион байгуулж, цуглуулсан болон хадгалсан мэдээллийг устгасан, холбогдох дүрэм, журмыг хуульд нийцүүлсэн тухай тайлан, мэдээг нэгтгэж, тогтоосон хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг Захиргаа удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга (Л.Эрдэнэбат)-д даалгасугай.

ОРЛОГЧ ДАРГА



Т.ГАНЗОРИГ

3150600143